



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2012 оны 06 сарын 20 өдөр

Дугаар 205

Улаанбаатар хот

“ОСАБ ББСБ” ХХК-ийн банк бус санхүүгийн  
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг  
хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.5, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 11.2, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 186 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 10.5.5 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “ОСАБ ББСБ” ХХК-ийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.
2. Компанийн оноосон нэрээс “ББСБ” гэсэн тэмдэглэгээг хасуулж, үйл ажиллагааны чиглэлээ өөрчлүүлэхийг “ОСАБ ББСБ” ХХК /М.Эрдэнэсүвд/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллах болон олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН